United Nations Development Programme

No:
Ref:

Date: September 07, 2020

МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ НООЛУУРЫН ПЛАТФОРМ
Тогтвортой Ноолуурын Зөвшилцөлд хүрэх ажлын хэсгийн уулзалтын тэмдэглэл

Хаана: НҮБ-ын байр, 6 давхрын хурлын танхим
Хэзээ: 2020 оны 9-р сарын 07-ны өдөр, 13:00-17:00
Хурал удирдсан: МТНПлатформын менежер

Оролцогчид

№	Ажлын хэсгийн гишүүд	МТНПлатформ
Оролцсон	1. Б.Эрхэмбаяр, ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ноос, ноолуурын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	15. В.Шинэнэмэх, НҮБХХ.Монголын Тогтвортой Ноолуурын Платформ, Менежер 16. О.Одгэрэл, НҮБХХ.Монголын Тогтвортой Ноолуурын Платформ, Мэдээлэл харилцааны менежер, 17.Н.Цолмон, НҮБХХ. Монголын Тогтвортой Ноолуурын Платформ, Ажилтан
	2. Б.Баясгалан, МННХ, Баталгаажуулалтын алба хариуцсан мэргэжилтэн	
	3. Б.Батхишиг, SFA, Монгол дахь салбарын захирал 4. У.Сарангоо, AVSF СтэпЭкоЛаб Төсөл, Төслийн зохицуулагч 5. Ж.Чанцаллхам, WCS, Төслийн зохицуулагч 6. А.Энх-амгалан, БСТ, Захирал 7. Ц.Энх-амгалан, GG АНР, Төслийн зохицуулагч 8. У.Тунгалаг, ЛАСН, Монгол дахь салбарын захирал 9. Ю.Баяржаргал,TNC, Хөтөлбөрийн захирал 10. Л.Ганцогт, МБАНХ, Зөвлөх	
	11. Г.Эрхэмболд, Snowfields ХХК, Менежер 12. Ч.Батцэцэг, Нанс Кашимер ХХК, Менежер 13. Г.Гантахь, Ханбогд ХХК, Борлуулалт хариуцсан захирал	
	14. Р.Бадмаанямбуу, ШУТИС, Ахлах багш	
Оролцоогүй	1. Б.Бадруун, ХХААХҮЯ, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга 2. Ж.Эрдэнэсувд, МННХ, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн 3. П.Болормаа, Монгол дахь ОУ-ын Хөдөлмөрийн Байгууллага, Үндэсний Зохицуулагч 4. Э.Нандин-эрдэнэ, Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо, Төслийн Менежер 5. Д.Буянаа, Монитал ХХК, Захирал 6. Д.Цэрэнлхам, Гурван Сор ХХК, Захирал	

Ажлын хэсгийн уулзалтаас гарах зорилтот үр дүн:

- Тогтвортой Ноолуурын тодорхойлолтын драфтын талаар Зах Зээлийн Зөвлөх Хорооны өгсөн санал, зөвлөмжийг танилцуулах;
- “Тогтвортой ноолуур”-ын тодорхойлолтыг эцэслэх;
- Тодорхойлолтыг оролцогч талуудын дунд хэлэлцүүлэх, зөвшилцөлд хүрэх;

ХӨТӨЛБӨР

Цаг	**Үйл ажиллагаа**	**Илтгэгч/хариуцагч/тайлбар**
13:00-14:00	Бүртгэл, үдийн цай	
14:00-14:10	Платформын ажлын явцын талаар сүүлийн үеийн мэдээлэл өгөх	В.Шинэнэмэх НҮБХХ-ийн МТНП-ын, Менежер
14:10 – 14:25	“Тогтвортой ноолуур”-ын драфт тодорхойлолт боловсруулахад мөрдсөн аргачлал, үйл явцын талаарх мэдээлэл, томъёолж гаргасан үр дүнг танилцуулах (сануулах зорилготой)	У.Сарангоо, СтэпЭколаб төслийн зохицуулагч, AVSF Могнолын Тогтвортой Текстилийн Эвслийг үүсгэн байгуулагч
14:25 – 14:55	“Тогтвортой ноолуур”-ын драфт тодорхойлолтод Зах Зээлийн Зөвлөх Хорооны гишүүд, олон улсын брэнд компаниудаас өгсөн санал, шүүмжийг танилцуулах	В.Шинэнэмэх НҮБХХ-ийн МТНПлатформ
14:55 – 15:40	Хэлэлцүүлэг	Модераторыг сонгоно
15:40 – 16:10	“Тогтвортой ноолуур”-ын тодорхойлолтыг эцэслэх	Платформын баг
16:10 – 16:40	Тодорхойлолтыг оролцогч талуудын дунд хэлэлцүүлэх, зөвшилцөлд хүрэх стратеги, Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах	Платформын баг
16:40 – 17:00	Дүгнэлт, дараагийн алхмууд	Платформын баг

Хэлэлцүүлгийн хураангуй

1. **Платформын зүгээс хийгдсэн ажлуудын талаар шинэчилсэн мэдээлэл өгөх**

НҮБХХ-ийн дэргэдэх Монголын Тогтвортой Ноолуурын Платформын Менежер В.Шинэнэмэх уулзалтыг нээж Платформын зорилго, одоог хүртэл хийж байгаа ажлын талаар шинэчилсэн мэдээлэл өгөв.

2. **“Тогтвортой ноолуур”-ын драфт тодорхойлолт боловсруулахад мөрдсөн аргачлал, үйл явцын талаарх мэдээлэл, томъёолж гаргасан үр дүнг танилцуулах**

AVSF, StepEcoLab төслийн зохицуулагч У.Сарангоо “Тогтвортой ноолуур”-ын драфт тодорхойлолт боловсруулахад мөрдсөн аргачлал, үйл явцын талаарх мэдээлэл, томъёолж гаргасан үр дүнг гишүүдэд дахин сануулах байдлаар танилцуулав.

ЛАСН, У.Тунгалаг: Платформын үйл ажиллагаа хэр удаан үргэлжлэх вэ? Санхүүжилт нь яаж шийдэгдэж байгаа вэ?

МТНП, В.Шинэнэмэх: GEF-ийн санхүүжилтээр БОАЖЯ ба UNDP-ийн хэрэгжүүлж буй ENSURE төслөөс 2020 оны санхүүжилтийг шийдсэн. Ирэх оны буюу 2021 оны санхүүжилтыг одоогийн байдлаар 60-70 хувь нь шийдвэрлэгдэх шатандаа байна. Дараа жилийн төсөв, санхүүжилтийг UNDP-ийн ENSURE төслийн хүрлаар ороод үйл ажиллагаа болон, санхүүжилтын асуудлыг тодорхой болгоно. Харин цаашдаа бол Платформыг үндэсний байгууллагууд хамтран өөрсдөө авч явах юм. Энэ асуудлыг 2021 оны ажлын төлөвлөгөөнд тусгаад яах тухайгаа хоорондоо ярилцаж шийдэх юм.

AVSF StepEcoLab, У.Сарангоо: Бид 10 хэдэн жил тус тусдаа төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд тодорхой үр дүнд хүрсэн байна. Одоо харин нэгдэж, хүчээ нийлүүлэх цаг болсон гэж үзээд SDC, SFA, StepEcoLab төсөл, МБАНХ, МННХ зэрэг 5 байгууллагын санаачлагаар Монголын Тогтвортой Текстилийн Эвслийг байгуулсан. Энэхүү Эвслийн дараалсан хурлуудаар Тогтвортой Ноолуур, Тогтвортой үйлдвэрлэл гэдэг нэгдсэн нэг тодорхойлолттой байх ёстой юм байна гэж шийдвэрлэсэн. Гурван хурал дамжин тогтвортой ноос, ноолуур гэх тодорхойлолтыг байгууллага болгон өөрсдийн хувилбараар гаргаж ирсэн бөгөөд эндээс түлхүүр үгс, нийтлэг хэрэглэгдэж байгаа үгнүүдийг шүүж тодорхойлолтын анхны хувилбарыг бий болсон. Дараа нь энэхүү тодорхойлолтоо дахин хэд хэдэн удаа хуралдаж ярилцаад бидний хувьд хамгийн сүүлийн хувилбарыг Тогтвортой байдлын тулгуур 3 бүрэлдэхүүний хүрээнд brainstorming хийж, нэмүү өртгийн сүлжээг бүхэлд нь хамрах дараах тодорхойлолтыг гаргаж ирсэн. “Ил тод, тасралтгүй, ёс зүйтэй, мөшгих боломжтой, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө нь хэмжигддэг, амьтдын эрхийг хангасан, ашгийн шударга хуваарилалттай, нэмүү өртгийн сүлжээний үян хатан, чадамжтай байдлыг хангах хариуцлагын системийг хэлнэ”. Энэ тодорхойлолт нь нэмүү

өртгийн сүлжээг бүхэлд нь хамарч байгаа учраас сүлжээний оролцогч бүрийн хувьд илүү нарийвчлалтай дэд тодорхойлолт гарч болохыг үгүйсгэхгүй.

3. **“Тогтвортой ноолуур”-ын драфт тодорхойлолтод Зах Зээлийн Зөвлөх Хорооны гишүүд, олон улсын брэнд компаниудаас өгсөн санал, шүүмжийг танилцуулах**

МТНП, В.Шинэнэмэх: Олон улсын брэндүүдэсс бүрдсэн ЗЗЗХ-оос бидний гаргасан драфт дээр feedback өгсөн. Одоо та бүхэнд танилцуулья. Нэгд, нийтлэг тодорхойлолттой болохыг зорьж байгаа нь дэвшилттэй байна. Хоёрдугаарт, уг тодорхойлолт нь Тогтвортой байдлын 3 тулгуур бүрэлдэхүүн хэсгүүдэд үндэслэн цогц, нэгдмэл байхыг зорьсон нь эерэг байна. Мал амьтны тавлаг байдлыг хангах талаар орулсан ны сайшаалтай. Resilience-ийг түлхүүр үг болгож оруулах. Олон төсөл, санаачлагуудын тэгш оролцоог хангах нь их чухал гэж үзсэн. Тодорхой болгох заалтуудын хувьд ёс зүйтэй, тасралтгүй гэх тодорхойлолт сүлжээний оролцогч бүрийн хувьд өөр өөр зүйлийг илэрхийлэх учраас илүү тодруулахыг санал болгосон. Тогтвортой ноолуур гэдгийг хариуцлагатай гэдгээс илүү хүчтэй үгээр тодруулж нөхөн сэргээлт тал руу нь оруулах шаардлагатай гэж үзсэн. Мөшгих системийн хувьд нэг бүрчлэн мөшгих систем хэрэгтэй юу, масс баланс байж болох уу гэдгийг харгалзан үзэх. Энэ тал дээр төслүүдээс санал авмаар байна. Мал амьтны тавлаг байдлын хувьд үндсэн 3 биш 4 бүрэлдэхүүн хэсэгтэй болгохыг, яг Монгол ямаанд тохирсон нөхцөлүүдийг оруулахыг санал болгосон. Нийгмийн асуудал дээр албадан хөдөлмөр, хөдөлмөр эрхэлж буй цагаач иргэд, хүүхдийн хөдөлмөр зэргийг анхаарч өгөөч гэсэн. Мөн хөдөлмөрийн хөлсний асуудлыг тодорхой болгоорой гэсэн. Нийтээр нь өгөх зөвлөмж дээр уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг оруулахыг санал болгосон. Ноолууран ширхэгтийн чанарын үзүүлэлтийг оруулбал салбар нь илүү тогтвортой байх боломжтой гэдэг зөвлөмж өгсөн. Мал, амьтны эрхийг хамгаалдаг байгууллагуудтай нэмүү өртгийн сүлжээний оролцогчид харилцаанд орох сургалт хийж бэлтгэл хангах нь чухал гэж үзсэн. Олон параметр-тэй учир ач холбогдлоор нь ангилах хэрэгтэй гэж үзсэн. Малчдын дуу хоолой, оролцоог хангах нь их чухал гэдэг санал маш олон удаа давтагдсан. Платформын баг 10 сарын эхээр Баянхонгор аймгийн 2 суманд ENSURE төслийнхөнтөй хамт явж малчидтай уулзах гэж байна.

4. **“Тогтвортой ноолуур”-ын тодорхойлолтыг эцэслэх**

SFA, Б.Батхишиг: Манай байгууллагын зүгээс энэ ажилд анхнаас нь оролцоод тогтвортой ноос, ноолуурын тодорхойлолтыг өөрсдийн хувилбараар гаргаж Англи, Монгол хэлээр бичиж явуулсан байгаа.

БСТ, А.Энх-амгалан: Энэ тодорхойлолтыг брэндүүдийн шаардлагын дагуу тодорхойлох гээд байна уу эсвэл эд нар өөрсдөө ч ороод явж байна уу?

AVSF, StepEcoLab У.Сарангоо: Системээр нь авч үзэж байгаа. Түүхий эдээс эхлээд үйлдвэрлэгч хүртэлх нийлүүлэлтийн сүлжээ бүхэлдээ тогтвортой арга аргачлал, хандлагатай байж байж салбар бүхэлдээ тогтвортой болно.

SFA, Б.Батхишиг: Манай байгууллагын хувьд суурь зарчмуудаа гаргасан.

МННХ, Баясгалан: Ажлын хэсгийн гол ажил нь 3 тулгуур бүрэлдэхүүн хэсгийг үндэслэн суурь зарчмуудаа гаргасан. Эндээс цаашаа нэмүү өртгийн сүлжээний оролцогч болгон дээр задарч гарч ирнэ.

ЛАСН, У.Тунгалаг: Одоогийн тодорхойлолт нь үйл явцыг илүү дүрсэлсэн байна. Тогтвортой ноолуур гэдэг нь гэсэн учраас энэ бүтээгдэхүүнээ илүү тодруулж гаргасан байх нь зүйтэй байх. Тэр бүтээгдэхүүнийг гаргах үйл явц нь тусдаа орж болох байх.

GG АНР, Ц.Энх-амгалан: Тодорхойлолтыг баталгаажуулах өгөгдлийн сан, нотолгоо байх ёстой гэж бид үзсэн. Манай төслийн хувьд өндөр үнэтэй эдийн засаг руу холбож өгөх гол зорилготой байдаг учир нийлүүлэлтийн сүлжээний шатлал бүрийг тодорхой болгох хэрэгтэй байх. Малын эрүүл мэндийг сайжруулах ажилд мөшгих тогтолцоог маш амжилттай ашиглаж байгаа. Энэ ажлыг төрийн хэмжээнд дэмжээд, өргөжүүлээд явахгүй бол ганц ТББ хүчрэхгүй нь.

ХХААХҮЯ, Б.Эрхэмбаяр: Монгол Улс жилд 10,000 тонн ноолуур бэлтгэж байгаагаас 2,000 орчим тонныг л дотооддоо авч үлдэж чаддаг. Тогтвортой байдлын тухай асуудал нийт нөөцийнхөө хэмжээнд буюу 10,000 тонн ноолуур дээр яригдаж байна уу, эсвэл авч үлдэж байгаа тоо хэмжээн дээр яригдах уу гэдгийг их сайн бодох хэрэгтэй. Малчид илүү үнэ санал болгож байгаа хүнд л өгч байна. Малчин хүний сэтгэлгээ, хариуцлагыг яаж дээшлүүлэх вэ? Яаж дотооддоо өгдөг болгох вэ? Чанар, тоон дээр яаж баланс барьдаг болгох вэ?

МТНП, В.Шинэнэмэх: Хувийн хэвшлийнхнийг сонсьё. Төслүүдийг бас сонсьё. Эрхэмбаярын асуултанд хариулт гарч ирэх байх.

WCS, Ж.Чанцаллхам: Тодорхойлолт гаргахдаа сөрөг биш эерэг үр дүнг голлож тодорхойлбол ямар вэ?

БСТ, А.Энх-амгалан: Сарангоотой санал нийллээ. Миний гаргасан драфт бол “Бэлчээр, малд ээлтэй аргаар бэлтгэсэн чанартай түүхий эдээр байгаль орчны сөрөг нөлөөгүй, мөлжлөгөөс ангид хөдөлмөрөөр бүтээснийг нь мөшгиж магадлах боломжтой бүтээгдэхүүнийг тогтвортой бүтээгдэхүүн/процесс гэнэ”.

TNC, Ю.Баяржаргал: Байгаль орчин, бэлчээрийг онцолж, тодорхойлолтыг ийм тодотголоор эхлэх нь зүйтэй байх. Тогтвортой ноолуурын суурь нь бэлчээр, байгаль орчны асуудал учраас олон улсын хэмжээнд ч ингэж онцлох нь чухал болоод байгаа.

ЛАСН, У.Тунгалаг: Би Баяржаргалын саналыг дэмжиж байна. Иймээс Энх-Амгалангийн гаргаж ирсэн тодорхойлолт дээр бэлчээрийн экосистем, мөн зэрлэг амьтныг нэмж оруулаад “бэлчээрийн экосистем, зэрлэг амьтан, малд ээлтэй аргаар бэлдсэн...” гэх мэт үргэлжлүүлбэл амьтан ургамал, амьдрах орчин бүхэлдээ тусгагдана.

WCS, Ж.Чанцаллхам: Бидний гаргаж байгаа энэ шийдвэрүүд, хийгдэж байгаа ажлуудын талаар ХХААХҮЯ, БОАЖЯ гэх мэт бодлого тодорхойлдог Яамд мэдээлэл сайтай байх хэрэгтэй байх. Бодлого гаргахаас нь өмнө сайн мэдээлэл өгдөг, хүргэдэг баймаар байна.

МТНП, В.Шинэнэмэх: Платформын Ковид-ын ажлын хэсгээс 3Г-ийн үйл ажиллагааны 5 жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар бодлогын 4 зөвлөмж бэлдэж өгсөн. МННХ-оос гаргасан төрийн, төрийн бус гэх зэрэг олон талт оролцоог хангасан Cashmere board байгуулах санал ёсоор Ноолуурын Зөвлөл байгуулах санал, мөн түүнчлэн бие даасан Ноолуурын Сан байгуулах гэх мэт саналуудыг оруулсан.

МННХ, Б.Баясгалан: Бодлогын түвшинд албажуулаад энэ Зөвлөлийг байгуулах нь их чухал гэж Холбоо үзэж байгаа. Процессыг жаахан хурдасгаад өгөх хэрэгтэй байна. Нийгмийн асуудал, байгаль орчны асуудлаар дараа дараагийн уулзалтууд дээр Байгаль Орчны Яам нилээн хүчтэй оролцох ёстой болов уу гэж бодож байна.

ШУТИС, Р.Бадмаанямбуу: Тодорхойлолтыг их чамбай, сул үггүй боловсруулах хэрэгтэй болов уу. Монгол ноолуурын хувьд бэлчээрийн, нүүдлийн МАА гэдгээ давуу тал болгон үг, үсгээ их оновчтой сонгож тодотгох нь зүйтэй байх. Тэгээд мэдээж тогтвортой байдлыг тодорхойлдог 3 тулгуур бүрэлдэхүүнийг үндэслэн гаргаж ирэх нь зөв. Миний хувийн бодлоор sustainable гэдгийг тогтвортой биш ээлтэй гэж орчуулбал илүү тохиромжтой болов уу гэж боддог.

МТНП, В.Шинэнэмэх: Тодорхойлолт, тайлбар хоёрыг салгаж, нийтлэг зарчим дээрээ үндэслэн тухайн шатлал, оролцогч бүрийн хувьд нэмэлт тайлбар гарч ирэх байх. Одоо гаргаж ирсэн хувилбар дээрээ ажиллацгаая. Ямар байдлаар хэлэлцүүлэх үү, хэзээ эцсийн хувилбараа гаргаж ирэх үү? ХХААХҮЯамны хувьд энэ бүх процесс та бүхний ажлын нэг хэсэг гэж хүлээж аваасай гэж хүсэж байна. Тэгж хандвал ажил илүү урагшлах байх.

ZSL, У.Тунгалаг: Хөгжлийн бодлого боловсруулах ажилд тодорхой процессыг дамжин, тодорхой компонент, бүрэлдэхүүн хэсгээр боловсруулдагтай энэ тодорхойлолт гаргах ажил төстэй. Нэг тодорхойлолтод бүх зүйлийг багтаах гэж оролдох нь бүтэхгүй. Иймд тогтвортой ноолуураа бүтээгдэхүүний хувьд тодорхойлж гаргачихаад араас нь тухайн бүтээгдэхүүн ямар үйл явцаар буй болох учиртайг үйлдвэрлэх зарчим болгон оруулж болох байх. Мөн бусад хүмүүсийн ач холбогдол өгөөд байгаа уламжлалт монгол орчинд буй болж буй ноолуур гэдгийг онцлох нь зөв. Бидний зүгээс buyers-ийн шаардлагыг хангахаас гадна бас өөрсдийн эрх ашиг, онцлог, уламжлалыг тусгах хэрэгтэй.

МТНП, В.Шинэнэмэх: Бүх талуудын сонирхол, шаардлагыг тусгахыг хичээж байгаа.

ХХААХҮЯ, Б.Эрхэмбаяр: Ноолуур бэлтгэлийн үеэр Арилжааны банкнаас олгодог 12%-ийн зээлийн хүүг 75%-ийг нь Яам, үлдсэн 25%-ийг нь компаниуд өөрсдөө даадаг. 21 онд Ноолуур хөтөлбөр дуусах гэж байна. Тогтвортой Ноолуурын талаар хийгдэж буй энэ ажлууд бидний зарчим, зорилготой яаж уялдах вэ? Хөтөлбөрөө тодорхой болгоод Платформын үйл ажиллагаатай яаж холбох вэ? Сүлжээний ашгийн тэгш хуваарилалтыг яаж зохицуулах вэ?

МТНП, В.Шинэнэмэх: Ноолуур хөтөлбөр үргэлжлэх үү?

ХХААХҮЯ, Б.Эрхэмбаяр: Шинэ хөтөлбөр гаргах биш харин үргэлжлэх байх.

AVSF, StepEcoLab У.Сарангоо: Хөтөлбөр 4 жил хэрэгжээд дуусдаг биш 12 жил ч юм уу илүү урт хугацааны, том алсын хараатай хөтөлбөр баймаар байна.

ХХААХҮЯ, Б.Эрхэмбаяр: Ноолуурын зах зээлээ эдийн засгийн хөшүүргээр яаж хамгаалах тухай ярилцах уу?

WCS, Ж.Чанцаллхам: Дотоодын үйлдвэрүүдэд зээл өгч байгаа ч гадаад зах зээл дээр өрсөлдөх чадвар муу байгаа учир татварын бодлогоор дэмжмээр байна. Угааж самнаад урагшаа гаргаж байгаа урсгалыг зогсоомоор байна. Мөн стандартад суурилсан үнийн бодлого барих хэрэгтэй байх

МТНП, В.Шинэнэмэх: SFA зэрэг байгууллага шиг гадны зах зээлтэй шууд холбож өгөх бодлого хэрэгтэй байх.

SFA, Б.Батхишиг: Ковид-той холбоотойгоор гадны хариуцлагатай зах зээл баталгаажсан, хариуцлагатай эх үүсвэрээс худалдан авалт хийнэ гэдэг амлалт өгчихсөн байгаа. Тодорхойлолтын хувьд хэдүүлээ зарчим, тодорхойлолт хоёроо салгая гээд тохирчихлоо. Одоо тэгэхээр бүтээгдэхүүний түвшинд тодорхойлох уу, үйлдвэрлэлийн түвшинд тодорхойлох уу гэдгээ тохирох хэрэгтэй юм байна. Үйлдвэрлэгчийн хувьд самнасан ноолуур ч бүтээгдэхүүн. Малчдын хувьд түүхий ноолуур нь бүтээгдэхүүн. Тэгэхээр бүтээгдэхүүн дээр гарч ирэх байх гэж бодож байна. Бүтээгдэхүүн хийх процесс нь өөрөө агуулгандаа орчих байх.

AVSF, StepEcoLab У.Сарангоо: Бүтээгдэхүүн дээр голлохоор Хаан ширхэгт шиг бүтээгдэхүүний шинж чанарын үзүүлэлт рүү хэтэрхий хэлбийчих байх. Бидний гаргах гээд байгаа тодорхойлолт тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа процесс нь sustainable байж байж баталгаажих болохоор системээр нь авч үзэх ёстой гэж бодож байна. Дэлхий нийтийн хандлага ч ийм байгаа.

МТНП, В.Шинэнэмэх: Задлаад тодорхойлохын тулд нийлүүлэлтийн сүлжээгээр авах уу, үйлдвэрлэлийн процессоор нь авч үзэх үү?

Уулзалтанд оролцогчдын ихэнх нь нийлүүлэлтийн сүлжээгээр явсан нь дээр гэж үзлээ.

МТНП, В.Шинэнэмэх: За тэгвэл бүтээгдэхүүнийг тодорхойлно гэдэг дээр санал нийлэх үү? Бүрэлдэхүүн хэсэг болгон дээр тайлбартай явах уу?

WCS, Ж.Чанцаллхам: Тодорхойлолт бүр дээр нэмэлт тайлбар ороод явах нь.

AVSF, StepEcoLab У.Сарангоо: Түүхий эдийн хэсэг, боловсруулалтын хэсэг гэж хоёр салгавал ямар уу? Тэгэхгүй бол энэ хоёр хэсгийн хувьд тайлбар өөр өөр гарч ирнэ.

МТНП, В.Шинэнэмэх: Бүтээгдэхүүн гэдэг дээр зөвшөөрч байна уу?

Бүгд зөвшөөрөв.

5. **Тодорхойлолтыг оролцогч талуудын дунд хэлэлцүүлэх, зөвшилцөлд хүрэх, ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах**

Тодорхойлолт дээр дахин ажиллаж сүүлийн хувилбарыг гаргав. Үүнд:

“Бэлчээрийн эко систем, мал амьтанд тавлаг*, тодорхой гарал үүсэлтэй* түүхий эдээр хүн, байгальд ээлтэйгээр* боловсруулсан, нэмүү өртгийн сүлжээний чанарын баталгаатай* бүтээгдэхүүнийг Монголын тогтвортой ноолууран бүтээгдэхүүн гэнэ”. Одтой хэсгүүд дээр нэмэлт тайлбар хийгдэнэ.

Дүгнэлт, дараагийн алхам:

- Тогтвортой Ноолуурын Зөвшилцөл техникийн ажлын хэсгийн зохицуулагчаар Платформын багийн хамтаар Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл (SFA) ажиллахаар тогтов. Эхний ээлжинд тодорхойлолтын шинэчилсэн хувилбарыг боловсруулах, Англи хэл дээр зөв зохистой буулгах ажлыг хамтран гүйцэтгэнэ – зорилтот хугацаа 9-р сарын 18-ний дотор
- Шинэчилж ажилласан Тогтвортой Ноолуур тодорхойлолтын эцсийн хувилбарыг ажлын хэсгийн гишүүдэд илгээж, задаргаан дээр санал авах - зорилтот хугацаа 9-р сарын 25-ны дотор
- Санал ирсэн хувилбарыг бүх оролцогч талуудын дунд цахимаар хэлэлцүүлж, зөвшилцөөд эцсийн хувилбар гаргах - зорилтот хугацаа 10-р сарын 09-ний дотор

Тэмдэглэл хөтөлсөн – Н.Цолмон, Платформын ажилтан